

## АГУУЛГА

<b>Бүлэг 1. Төслийн товч танилцуулга.....</b>	<b>5</b>
1.1. Төслийн талаарх мэдээлэл.....	5
1.2. Ордын хүдрийн найрлага, технологийн судалгаа .....	8
Барилгын чулууны бетоны орцын нормыг тогтоосон лаборатори-технологийн туршилтын үр дүн.....	11
Лабораторийн шинжилгээ, туршилтын дүгнэлт .....	11
1.2. Ашиглалтын системийн сонголт.....	12
Ил уурхайн олборлолт .....	13
1.4. Уурхайн хүчин чадал, дэд бүтэц .....	13
<b>Бүлэг 2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга.....</b>	<b>25</b>
2.1. Уур амьсгал өнөөгийн төлөв байдал .....	25
2.2. Агаарын чанар өнөөгийн төлөв байдал .....	25
2.3. Газрын гадарга, хэвлэй өнөөгийн төлөв байдал.....	26
2.4. Төслийн талбайн гадаргын усны төлөв байдал .....	27
2.5. Хөрсөн бүрхэвч өнөөгийн төлөв байдал: .....	28
2.6. Ургамлан бүрхэвч өнөөгийн төлөв байдал .....	29
2.7. Төслийн талбай орчмын амьтны аймаг .....	30
<b>Бүлэг 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....</b>	<b>31</b>
3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	31
3.2. Газрын гадарга, хэвлэй болзошгүй нөлөөлөл: .....	31
3.3. Усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл .....	32
3.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	32
3.5. Ургамлан бүрхэвчид, амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл .....	33
3.6. Нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөлөл: .....	34
<b>Бүлэг 4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ .....</b>	<b>35</b>
<b>Бүлэг 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....</b>	<b>36</b>
<b>Бүлэг 6. Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө .....</b>	<b>39</b>
<b>2024 оны хувьд уурхайн ашиглалтын карьерт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхгүй. ....</b>	<b>39</b>
<b>Бүлэг 7. Биологийн олон янз байдлыг Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....</b>	<b>40</b>
7.1. Эвдрэлд орж орхигдсон газрын нөхөн сэргээлт .....	40

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

7.3. Хөв цөөрөм байгуулах.....	45
<b>Бүлэг 8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө</b>	
.....	46
<b>Бүлэг 9. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....</b>	46
<b>Бүлэг 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....</b>	48
<b>Бүлэг 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....</b>	50
<b>Бүлэг 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....</b>	51
<b>Бүлэг 13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....</b>	54
<b>Бүлэг 14. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь .....</b>	55
<b>Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөөний нэгдсэн төсөв, дүгнэлт</b>	
.....	56
<b>Хавсралт .....</b>	59

**Хүснэгтийн жагсаалт**

<b>Хүснэгт 1. Төслийн талбайн байршил .....</b>	5
<b>Хүснэгт 2. Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд .....</b>	8
<b>Хүснэгт 3. Химийн найрлагын шинжилгээний үр дүн.....</b>	11
<b>.Хүснэгт 4. “Түшлэг уул”-ын барилгын чулууны ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт ....</b>	12
<b>Хүснэгт 5. Ашиглалтын технологийн процессууд .....</b>	13
<b>Хүснэгт 6. Ил уурхайн олборлолтонд өртөх геологийн нөөцийн хэмжээ .....</b>	13
<b>Хүснэгт 7. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо .....</b>	13
<b>Хүснэгт 8. Уурхайн ажлын үргэлжлэх хугацаа.....</b>	14
<b>Хүснэгт 9. Ашиглалтын системийн үндсэн элементүүд .....</b>	14
<b>Хүснэгт 10. Орд эзэмшигчид бэлэн байгаа тоног төхөөрөмжүүд .....</b>	15
<b>Хүснэгт 11. Өрмийн машины үзүүлэлт .....</b>	15
<b>Хүснэгт 12. Экскаваторын үзүүлэлт.....</b>	16

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 13. Автосамосвалын үзүүлэлт.....	17
Хүснэгт 14. Doosan SD300 утгуурт ачигчийн үзүүлэлт .....	18
Хүснэгт 15. Тэсэлгээний ажлын тооцоо .....	19
Хүснэгт 16. 2024 онд зарцуулах ТБ-ын нийт хэмжээ .....	19
Хүснэгт 17. Бүтээгдэхүүний баланс.....	21
Хүснэгт 18. Доргилтот шигшүүр .....	24
Хүснэгт 19. Төслөөс усны чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	32
Хүснэгт 20. Уурхайн эвдрэлд орох талбай .....	32
Хүснэгт 21. Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл .....	33
Хүснэгт 22. Төслөөс ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл ....	33
Хүснэгт 23. Төслийн нийгэм эдийн засгийн нөлөөлөл.....	34
Хүснэгт 24. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	37
Хүснэгт 25.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	39
Хүснэгт 26. Техникийн нөхөн сэргээлтийн нийт зардал .....	43
Хүснэгт 27. Ногоон байгууламж байгуулах төлөвлөлт .....	43
Хүснэгт 28. Ногоон байгууламж, ойн зурvas байгуулах ажлын зардал .....	43
Хүснэгт 29. Хөв цөөрөм байгуулах төлөвлөгөө.....	45
Хүснэгт 30. Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө .....	50
Хүснэгт 31. 2024 онд хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	52
Хүснэгт 32. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	54
Хүснэгт 33. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа.....	55
Хүснэгт 34. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт.....	58

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Зургийн жагсаалт**

Зураг 1. Төслийн талбайн байршил.....	5
Зураг 2: . Уурхайн ерөнхий төлөвлөлтийн зураг .....	6
Зураг 3. Hyundai-300LC маркийн экскаватор.....	16
Зураг 4. NordBenz фирмийн 24тн даацтай автосамосвал .....	17
Зураг 5. Бутлах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн технологийн схем.....	21
Зураг 6. Чичиргээт тэжээгч .....	22
Зураг 7. Хацарт бутлуур.....	22
Зураг 8. Алхан бутлуурын техникийн үзүүлэлт .....	23
Зураг 9. Туузан конвейеруудын техникийн үзүүлэлт .....	23
Зураг 10. Доргилтот шигшүүр.....	23
Зураг 11. Хөрсний тархалтын зураг .....	28

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн талаарх мэдээлэл


Төсөл хэрэгжүүлэгч: "Бишрэлт түшлэг" ХХК

Төслийн байршил: Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт 1-р багийн нутаг Түшлэг уул хэмээх газар байрлах барилгын чулууны орд 84.5 га талбайд хэрэгжижээ.

#### Хүснэгт 1. Төслийн талбайн байршил

№	Хойд өргөрөг	Зүүн уртраг
1	44°48'16.9"	110°19'21.8"
2	44°48'16.9"	110°19'51.267"
3	44°47'34.6"	110°19'51.267"
4	44°47'34.6"	110°19'21.8"

#### Зураг 1. Төслийн талбайн байршил




2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Дорноговь аймгийн Өргөн сумын Түшлэг уул нэртэй 84.5 га талбай бүхий 2015/011Х дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг Дорноговь аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/569 тоот захирамжаар Бишрэлт түшлэг ХХК-нд олгосон. Уг орд дээр 2016 онд “Бишрэлт түшлэг” ХХК нь хайгуулын ажил хийн хайгуулын ажлын үр дүнг 2016 оны 07-р сарын 05-ны өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн бодитой (B) зэргээр 673136.4 м<sup>3</sup>, боломжтой (C) зэргээр 460802 м<sup>3</sup>, бодитой болон боломжтой (B+C) зэргээр 1133938.4 м<sup>3</sup> барилгын чулууны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж ЭБМЗ-ийн 2016 оны 07-р сарын 05-ны XX-07-13 тоот дүгнэлт, АМГТГ-ын даргын 2016 оны 08-р сарын 01-ний өдрийн Н/93 тоот тушаалаар баталгаажуулжээ.

Төсөлд ашиглалтын үеийн хаягдал 1.5 % буюу 12889.3 м<sup>2</sup>, бохирдол 0,08% буюу 950.2 м<sup>3</sup> байхаар тооцож геологийн бодитой В зэргийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В нөөцөд шилжүүлэн тооцсоноор барилгын чулууны үйлдвэрлэлийн нөөц нийт 847346.0 м байна. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 1.55 сая.м хөрс хуулалт хийхээр тооцжээ. Жилд 60 мян.мбарилгын чулуу олборлох хүчин чадлаар нийт үйлдвэрлэлийн нөөцийг 15 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн байна.

## Зураг 2: . Уурхайн ерөнхий төлөвлөлтийн зураг



2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын уул геологийн тогтоц, уул техникийн нөхцөл зэргийг харгалзан үзэж ил уурхайн хөрс хуулалтын ажлыг авто гадаад овоолготой ил уурхайн ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

Ил уурхайд FlexiROC D30 маркийн өрмийн машин 1 ширхэг, 1 м<sup>2</sup>-ийн шанаганы багтаамжтай Hyundai-300LC маркийн экскаватор 1 ширхэг, 25 тн-ын даацтай NordBenz маркийн автосамосвал 3 ширхэг, Komatsu D65E маркийн бульдозер 1 ширхэг, 3 м<sup>3</sup>-ын багтаамжтай Doosan 300 маркийн утгуурт ачигч 2 ширхэг, NISSAN Conder маркийн усалгааны ширхэг, Hyundai маркийн шатахуун түгээгүүрийн 1 ширхэг зэрэг төхөөрөмжүүдийг ашиглахаар төлөвлөжээ.

Барилгын чулууг бутлан ангилах технологи нь 2014 онд барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоогоор хийлгэсэн технологийн зааварт үндэслэн бутлан ангилна. Бутлан ангилах үйлдвэрийн хүчин чадал 60 мян. м<sup>3</sup>/жил байна.

Түшлэг уулын барилгын чулууны ордын ашигт малтмалыг бүрэн төлөөлөх чадвартай дээжийг авч технологийн заавар боловсруулах зорилгоор лабораторийн түвшний туршилт судалгааг Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, БАК-ийн эрдэс туршилтын лабораторт хийсэн байна.

Түшлэг уулын барилгын чулууны Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, БАК-ийн эрдэс туршилтын лабораторт хийсэн туршилтын үр дүнгээр барилгын чулуу нь авто замын чулууны шаардлагыг бүрэн хангаж байна, мөн барилгын бетоны үйлдвэрлэлд том дүүргэгчийн түүхий эдээр хэрэглэхэд шаардлагыг бүрэн хангаж байна гэж үзсэн бөгөөд бүтээгдэхүүний гарц 0-5мм нь 15%, 5-10мм нь 10% 10-20мм нь 60%, 20-40мм нь 15% тус тус байна гэж үзжээ. Дээрх бүтээгдэхүүн гаргалтын тооцоогоор ашиглалтын хугацаанд нийт 0-5мм нь 127.1 мян. м<sup>3</sup>, 5-10мм нь 84.7 мян.м, 10-20мм нь 508.4 мян.м<sup>3</sup>, 20-40мм нь 127. 1 мян. м<sup>2</sup> бүтээгдэхүүн тус тус гаргахаар байна.

Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг ордоос 1.5 км зайд байрлах Сайншанд-Замын-Үүд хооронд татсан 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамнаас цахилгаан эрчим хүчээр хангахаар төсөлд тусгажээ. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 323.8 сая.төгрөг зарцуулахаар тооцоолсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 26.9 сая төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 98.6 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 50.1 сая төгрөг, хаалтын зардалд 48.2 сая төгрөг тус тус зарцуулахаар төсөлд тусгажээ. Уг төслийг хэрэгжүүлснээр 24 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 1000.0 мян.төг байхаар байна.

**Төслийн зорилго:** Бишрэлт Түшлэг ХХК-ийн уулын чулуу бутлан ангилах үйлдвэр нь 2012 онд байгуулагдаж Дорноговь аймгийн Өргөн сумын 1-р багийн нутагт Түшлэг уулын орд газар өөрийн үйлдвэрийн байранд 23 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Энэ бүтээгдэхүүн нь барилга, байгууламж болон зам талбайн ажлын үндсэн материал болох бетон зуурмагийн дүүргэгч материалыг эх орныхоо түүхий эд уулын чулууг буталж дайрга үйлдвэрлэснээр үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр нэмэгдүүлэх, стандартын шаардлага хангасан чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оршино.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Хүснэгт 2. Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд**

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Тоо, хэмжээ
1	Ордын геологийн нийт нөөц /В+С/	мян.м <sup>3</sup>	1133.9
2	Үйлдвэрлэлийн нөөц	мян.м <sup>3</sup>	847.346
3	Хаягдал	мян.м <sup>3</sup>	12.9
4		%	1.5
5	Бохирдол	мян.м <sup>3</sup>	0.9
6		%	0.8
7	Уурхайн жилийн хүчин чадал	мян.м <sup>3</sup>	60.0
8	Ажиллах горим: - жилд ажиллах хоног - хоногт ажиллах ээлж - ээлж үргэлжлэх хугацаа	хоног ээлж цаг	152 1 12
9	Ашиглалтын систем	<b>Авто тээвэр, гадаад овоолготой</b>	
10	Ажиллагсдын нийт тоо	хүн	24
11	Ордыг ашиглах хугацаа	жил	15
12	Уурхай байгуулах бэлтгэл үе шат	жил	0.3
13	Төслийн хүчин чадлаар ажиллах хугацаа	жил	14
14	Бутлан ангилах үйлдвэрийн байршил	<b>Тусгай зөвшөөрөл бүхий талбайдаа</b>	
15	Бүтээгдэхүүний жилийн гарц 5-10ММ 10-20ММ 20-40ММ	м <sup>3</sup>	9000 6000 36000 9000
16	Бүтээгдэхүүн борлуулалтын орлого	сая.төг	17775.0
17	Хөрөнгө оруулалтын хэмжээ	сая.төг	1286.0
18	Хөрөнгө оруулалт нөхөн төлөх хугацаа	жил	5
19	Төслийн ашгийн дотоод норм, IRR	%	33
20	Төслийн ирээдүйн мөнгөний үнэ цэнэ NPV, сая төгрөг	10%	1,837.33
21	1м <sup>3</sup> барилгын чулууны бүрэн өөрийн өртөг	мян.төг	14.6
22	Улсад төлөх нийт татвар төлбөрийн хэмжээ	сая.төг	2233.01
23	Цэвэр ашиг	сая.төг	4175.1
24	Уулын үндсэн тоног төхөөрөмжүүд:		
25	Экскаватор		1
26	Дугуйт ачигч		2
27	Автосамосвал, 25тн		3
28	Өрмийн машин		1
29	Бульдозер		1

**1.2. Ордын худрийн найрлага, технологийн судалгаа**

“Түшлэг уул”-ын барилгын чулууны ордын хайгуулын цооногоос авсан нийт 36 ширхэг сорьцод физик-механикийн хураангуй /асгаасын эзлэхүүн жин, нягт, бутлагдсан ширхгийн бүтэц, бутлагдалт, нимгэн үзүүрлэг хавтгайлаг хэсгийн агуулга, тоос шавар шороон хэсгийн агуулга/ шинж чанарын шинжилгээг БАК-ийн эрдэс туршилтын лабораторид хийлгэсэн.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Бутлуураар буталж шигшсэн дайрганы ширхгийн бүрэлдэхүүн хэсгийг бодитой ба боломжтой нөөцийн блок тус бүрээр тодорхойлбол: 20 мм-ийн шигшүүр дээрх үлдэгдэл бодитой /В/ нөөцийн хэмжээнд 32.0-65.2 %-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 50.35 %, боломжтой /С/ нөөцийн хэмжээнд 32-66.8 мм-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 51.9 %, 10 мм-ийн бодитой нөөцийн хувьд 28.1-51.2 %-ийн хооронд, дунджаар 40.59 %, боломжтой нөөцийн хувьд 28.1-51.2 %-ийн хооронд, дунджаар 38.5 %, 5.0 мм-ийн бодитой нөөцийн хувьд 3.9-22.3-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 10.29 %, боломжтой нөөцийн хувьд 3.9-22.3 %-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 10.1 % тус тус байна.

Үүнээс харахад ажлын гол фракц болох 10-20 мм-ийн шигшүүрийн үлдэгдлийн нийт хэмжээ 39.6-50.35 %-ийн хооронд хэлбэлзэж байгаа нь чулууг бутлахад ажлын фракцын гарцын хэмжээ их байх боломжтойг харуулж байна.

Мөн шигшсэн бутлагдалтын хэмжээ бодитой нөөцийн хувьд 6.9-18.5 %-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 12 %, боломжтой нөөцийн хувьд 9.4-17.8 %-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 12.8 %, асгаасын нягт бодитой нөөцийн хувьд 1367-1221.0 кг/м<sup>3</sup>-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 1272.8 кг/м<sup>3</sup>, боломжтой нөөцийн хувьд 1221-1329.0 кг/м<sup>3</sup>-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 1272.8 кг/м<sup>3</sup>, нимгэн үзүүрлэг хавтгай хэсгийн агуулга бодитой нөөцийн хувьд 5-19.4 %-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 8.33 %, боломжтой нөөцийн хувьд 4.4-19.4 %-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 8.61 %, тоос шавар шорооны хольцын хэмжээ бодитой болон боломжтой нөөцийн хүрээнд жигд 0.5 % тус тус байна.

Физик-механикийн хураангуй шинжилгээний үр дүнгээс харахад бутлагдалтын хэмжээ дунджаар 6.9-18.5 %-ийн хооронд байгаа нь техникийн шаардлагын 600-1000 маркад хамарагдаж, үзүүрлэг нимгэн хавтгай хэсгийн агуулгаараа үндсэн массынхаа 5.0-19.4 % байгаа нь шаардлагыг бүрэн хангаж, тоос шавар шорооны агуулга нь жигд 0.5 % байгаа нь техникийн шаардлагын 0.7 %-иас бага байна. Нөөцийн тооцоонд хамрагдсан сорьцуудын физик-механикийн хураангуй шинжилгээний үр дүнгээс харахад бүх үзүүлэлтүүд нь техникийн шаардлагын хүрээнд хангаж байна.

**Чулууны физик-механикийн бүрэн шинжилгээний чанарын тодорхойлолт**

“Түшлэг уул”-ын барилгын чулууны ордын бодитой ба боломжтой нөөцийн тооцоонд хамрагдаж байгаа хайгуулын цооног № 1,3,2,4,5-аас 5 ширхэг сорьцын физик-механикийн бүрэн шинжилгээний хариу, үр дүнгээр чулууны шинж чанар, зарим үзүүлэлтүүдийг сийрүүлбэл:

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Бодитой нөөцийн В блокийн хэмжээнд 20.0 мм-ийн фракцын шигшүүрийн үлдэгдлийн дунджаар 52.6 %, 10.0 мм-ийн фракцын үлдэгдлийн хэмжээ дунджаар 38.15 %, 5.0 мм-ийн фракцын үлдэгдлийн хэмжээ дунджаар 9.21 %, боломжтой нөөцийн С блокийн хэмжээнд: 20.0 мм-ийн фракцын хэмжээ дунджаар 53.55 %, 10.0 мм-ийн фракцын хэмжээ дунджаар 37 % тус тус байна. Дээрх фракцуудыг нэгтгэн физик-механикийн бүрэн шинжилгээгээр хавтгай хэсгийн агуулга 8.5 %, бутлагдсан хэсэг 100 %, тоос шавар шороон хэсгийн агуулга 0.5%, бүхэл шавар байхгүй, нягт- 2.63 г/см<sup>3</sup>, органик хольц шаардлага хангана. Чийглэг 0.2 %, нүх сувэрхэг байдал 0.9 % В-I блокийн хэмжээнд буталж шигшсэн асгаасын нягт дунджаар 1286 кг/м<sup>3</sup>, ширхгийн дундаж нягт 2.61 г/см<sup>3</sup>, ус шингээлт 0.9 %, бутрамтгай чанар 10.8 %, нимгэн үзүүрлэг 8.52 %, ширхэг хоорондын зайд 50.7 %, ширхгийн хэмжээ 5-20 мм тус тус байна.

Боломжтой нөөцийн хэмжээнд буталж шигшсэн асгаасын нягт 1273.5 кг/м<sup>3</sup>, ширхгийн дундаж нягт 2.6 г/см<sup>3</sup>, бутрамтгай чанар 9.5 %, нимгэн үзүүрлэг хавтгай хэсгийн агуулга 8.7 %, бутлагдсан хэсэг 100 %, шаварлаг тоосорхог лаг хэсгийн агуулга 0.4 %, бүхэл шавар байхгүй, нягт 2.6 г/см<sup>3</sup>, ус шингээлт 0.75 %, органик хольц шаардлага хангана. Чийглэг-0.2%, нүх сувэрхэг хэсэг 1.13 %, ширхэг хоорондын зайд-51.5% байна. 5.0-10.0 мм-ийн фракцын бутлах үеийн жингийн алдагдал 5.07-10.42 %-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 7.74 %, бат бөхийн марк дунджаар 1200, хүйтэн тэсвэрлэлт /хүчлийн натрийн уусмалд 10 мөчлөгийн дараах жингийн алдагдлаар/ 0.83-1.05 %-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 0.94 %, нимгэн үзүүрлэг хавтгайлаг хэсгийн агуулга 20.80-22.60 %-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 21.70 %, хэврэг хэсгийн агуулга 11.20-12.80 %-ийн хооронд хэлбэлзэнэ. Шинжилгээний дээрх үзүүлэлтүүдээс үзэхэд шинжилгээнд ирүүлсэн дээжийг буталж, шигшиж ялган 5 мм, 10 мм, 20 мм-ийн хэмжээтэй фракц болгон дээжид MNS 2998-2001 "Барилгын ажилд хэрэглэгдэх , байгалийн чулуулгаас бэлтгэсэн "-ийн шинжилгээний аргуудаар туршилтыг явуулжээ.

Физик-механикийн бүрэн шинжилгээний үр дүнг MNS390-98" Барилгын ажилд хэрэглэх техникийн шаардлага"-тай харьцуулж үзэхэд эзлэхүүн жин 2 г/см<sup>3</sup>-ээс их, нимгэн үзүүрлэг хавтгайлаг хэсгийн агуулга 8.3 %, цилиндрт шахсан дээжийн бат бөхийн марк 800-1200, хүйтэн тэсвэрлэлтийг хүхэр хүчлийн натрийн уусмалд хурдавчилсан аргаар 10 мөчлөг хийхэд жингийн алдагдал зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа зэрэг нь шинжилгээ хийгдсэн базальт чулуунаас гарган авсан дайргыг барилга, зам гүүрний ажилд хэрэглэх боломжтойг харуулж байна. "Түшлэг уул" ордын барилгын чулууны химиин найрлагын шинжилгээг хайгуулын шугамуудыг төлөөлүүлж шугам тус бүрээс 2-3 ш дээжид БАК-ын хими-эрдсийн районы лабораториид тодорхойлуулсан.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

### Хүснэгт 3. Химийн найрлагын шинжилгээний үр дүн

Дээж№	Химийн найрлагын агуулга ,%								
	SiO <sub>2</sub>	Al <sub>2</sub> O <sub>3</sub>	Fe <sub>2</sub> O <sub>3</sub>	SO <sub>3</sub>	CaO	MgO	K <sub>2</sub> O	Na <sub>2</sub> O	Ш.Г.Х
№12	68.01	12.87	3.47	0.16	7.21	2.83	0.34	0.64	4.12
№5	75.21	13.21	3.24	0.17	3.21	10.19	0.21	0.36	1.67
№18	69.23	11.81	5.17	0.08	6.17	2.23	0.18	0.41	3.22
№29	67.71	12.01	5.36	0.19	7.18	2.18	0.21	0.36	4.12
№37	69.81	11.36	5.20	0.13	6.21	2.07	0.13	0.21	3.12

### Барилгын чулууны бетоны орцын нормыг тогтоосон лаборатори-технологийн туршилтын үр дүн

“Түшлэг уул”-ын барилгын чулууны бутлан ангилсан дайргыг хүнд бетоны том дүүргэгч болгон ашиглах лаборатори-технологийн туршилт, шинжилгээний ажлыг БАК-ын Барилгын материал, технологийн районы төв бетон дүүргэгчийн лабораторид хийсэн. Энэ туршилт судалгааны үр дүн, бетоны орцын нормыг тогтоосон туршилтаас харахад базальт бутлан ангилсан MNS-1170:2009, MNS-1272:2009 стандартын дагуу хийсэн шинжилгээний зарим үзүүлэлтийг харуулбал: туршилтад орсон дайрганы ширхгийн хэмжээ 10-20 мм, ширхгийн дундаж нягт 2.61 г/см<sup>3</sup>, тоосорхог шаварлаг шэсгийн хэмжээ 0.4 %, ширхэглэл 5-40 мм, бутлагдалт 5.7 %, туршилтад орсон элсний нягт 2.61 г/см<sup>3</sup>, тоос шавар шорооны хольцын агуулга 1.6 %, ширхгийн модуль 2.65 байна.

Бетоны туршилтад Монгол улсын Дорноговь аймгийн Монцементийн үйлдвэрлэсэн PC-42.5 маркийн R<sup>3x0n</sup> нь 23.5 МПа-тай, 28 %-ийн хэвийн өтгөрөлттэй цемент оруулсан байна. Бетоны бэхжилтэд Sika ViscoCrete 5520 mn нэмэлтийг туршилтад орсон цементийн жингийн 1.2 %-тай тэнцэх хэмжээгээр оруулан туршсан байна. Туршилтын бөөн дээжийн физик-механикийн бүрэн шинжилгээний энэхүү үзүүлэлтүүд нь ордын бодитой ба боломжтой нөөцийн талбайд хамрагдсан сорьцуудын дундаж үзүүлэлтүүдтэй ижил байгаа нь тус дээж ордын ашигт малтмалыг бүрэн төлөөлж чадахыг харуулж байна. Ордын базальтын бетоны орцын найрлага, бетоны марк түүний чанарыг тодорхойлох зорилгоор лаборатори-технологийн 500 кг жинтэй нэг дээж авч Барилга Архитектур Корпорациын лабораторийд шинжлүүлж 500 маркийн бетоны орцын хэмжээ, шинж чанарыг лабораторийн нөхцөлд тодорхойлуулав.

Туршилтаар бетоны найрлагад 1019 кг базальт, 762 кг элс, цемент /M-42.5/ 440 кг, 180 кг ус, нэмэлт 0.41 кг тус тус оруулан туршилт явуулахад хольцын конусын суулт 0-20 см байна. Бетоныг уураар бэхжүүлсний дараах бат бэхийн үзүүлэлтээс харахад 500 хүртэл маркийн хүнд бетон үйлдвэрлэхэд Түшлэг базальт дайргыг том дүүргэгчээр ашиглах боломжтой нь энэхүү лаборатори технологийн туршилтаар тогтоолоо.

### Лабораторийн шинжилгээ, туршилтын дүгнэлт

- “Түшлэг уул”-ын барилгын чулууны ордын базальт чулуулгийн нөөцийн тооцоонд хамрагдсан сорьцуудын физик-механикийн хураангуй шинжилгээний үр дүн, тэдгээрийн бүх үзүүлэлтүүд нь MNS2998-2009 ба MNS390-98-ийн дагуу техникийн шаардлагыг хангаж байна.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- Бутлан ангилж, гарган авсан физик-механикийн шинжилгээний үр дүнг MNS390-98" Барилгын ажилд хэрэглэх чулууны техникийн шаардлага"-тай харьцуулж үзэхэд эзлэхүүн жин 2 г/см<sup>3</sup>-ээс их, нимгэн үзүүрлэг хавтгайлаг хэсгийн агуулга 8.8 %, цилиндрт шахсан дээжийн бат бөхийн марк 1340-1370, хүйтэн тэсвэрлэлтийг хүхэр хүчлийн натрийн уусмалд хурдавчилсан аргаар 10 мөчлөг хийхэд жингийн алдагдал зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа зэрэг нь шинжилгээнд орсон "Түшлэг уул"-ын базальтаас гарган авсан дайргыг барилга, зам гүүрний ажилд хэрэглэх боломжтойг харуулж байна.
- Ордын андезит бетоны орцын найрлага, чанарыг тодорхойлох зорилгоор лаборатори-технологийн 500 кг жинтэй нэг дээж авч Барилга архитектур корпорациын лабораториид шинжлүүлж 500 маркийн бетоны орцын хэмжээ, шинж чанарыг тодорхойлохоор бетоны найрлагад 1019 кг базальт, 762 кг элс, цемент /M-42,5/ 440 кг, 180 кг ус, нэмэлт 0.41 кг тус тус оруулан туршилт явуулахад хольцын конусын суулт 0-20 см байна.
- Туршилтын дүүргэгч материалыг хуурайгаар тооцож бетоныг уураар бэхжүүлсний дараах үеийн бат бөхийн үзүүлэлтээс харахад 500 хүртэл маркийн хүнд бетон үйлдвэрлэхэд Түшлэг уул ордын дайргыг том дүүргэгчээр ашиглах боломжтой нь тогтоогдсон.

## 1.2. Ашиглалтын системийн сонголт

Бодитой нөөцийн ашиглаж дууссан талбайд боломжтой нөөцийг бодитой нөөцөд шилжүүлэх гүйцээх хайгуулын ажлаар нөөцийг ихэсгэх ба талбайн гүнд нь өсгөх боломжтой. Геологи хайгуулын талбайд бодитой (B) нөөцийг 1 блок, (C) нөөцийг 2 блок болгон хувааж нөөцийг тус тус бодсон. Бодитой ба боломжтой нөөц нь эргэн тойронд эсвэл гүнд нь өсгөх боломжтой юм. Нөөц бодсон хэсэг өмнө нь дайрганы зориулалтаар ашиглаж байсан уулын орой хэсэг учир хөрс хуулалт байхгүй байна. Чулуулгийн эзлэхүүн жин 2.6 г/см<sup>3</sup>

### .Хүснэгт 4. "Түшлэг уул"-ын барилгын чулууны ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Нөөцийн зэрэг блокийн дугаар	Хайгуулын зүсэлт, дугаар	Блокийн нөөцийн талбай, м <sup>2</sup>	Зүсэлт дээр ашигт малтмалын тархсан талбайн дунджийг бодсон Томъё	Блокийн нөөцийн хэмжээ, м <sup>3</sup>	Чулуулгийн нягт, тн/м <sup>3</sup>	Блокийн нөөцийн хэмжээ, тн
B-1	I-I'	16828.41	V=S*H	673136.4	2.6	1750154.6
	II-II'					
Бодитой В нөөц				673136.4	2.6	1750154.6
C-II	I-I'	7283.94	V=S*H	291357.6	2.6	766270.5
C-III	II-II'	4236.11	V=S*H	169444.4	2.6	445638.8
Боломжтой С нөөц				460802	2.6	1211909.3
Ордын нөөц /B+C/				1133938.4	2.6	2962063.9

### Ил уурхайн олборлолт

#### Хүснэгт 5. Ашиглалтын технологийн процессууд

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто тээвэртэй ашиглалтын технологи	Хөрс хуулалт	Утгуурт ачигчаар түрэх Ухаж ачих Тээвэрлэх Гадаад овоолго
	Ашигт малтмал олборлолт	Өрөмдлөг, тэсэлгээний ажил Ухаж ачих Тээвэрлэх

#### Ил уурхайн хил хязгаар дахь геологийн болон үйлдвэрлэлийн нөөц

Ашиглалтын үед давхаргын ул ба таазнаас гарах хаягдлыг тус бүр 0.2 м-ээр, ашигт малтмалыг тээвэрлэх, овоолох үйл явцад 0.5 % гэж тус тус авч үзвэл нийт хаягдлын хэмжээ 12889.3 м<sup>3</sup> буюу балансын нөөцийн 1.5 % байна. Харин бохирдолтын зөвхөн блокийн хажуу хананд үүснэ гэж үзвэл нийт бохирдолтын хэмжээ нь 950.2 м<sup>3</sup> буюу үйлдвэрлэлийн нөөцийн 0.24 % байна.

#### Хүснэгт 6. Ил уурхайн олборлолтонд өртөх геологийн нөөцийн хэмжээ

№	Геологийн нөөц				
	Блокийн дугаар	Блокийн талбай	Нягт	Нөөцийн хэмжээ	
		m <sup>2</sup>	г/см <sup>3</sup>	m <sup>3</sup>	тн
1	B-I	16828.4	2.6	673136.4	1750154.6
2	C-II	7283.9	2.6	291357.6	766270.5
3	C-III	4236.1	2.6	169444.4	445638.8
4	Дүн		2.6	1133938.4	2962063.9

#### Хүснэгт 7. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Блокийн дугаар	Ашиглалтын нөөц							
	Уулын цул	Хөрс	Хаягдал		Бохирдол		Олборлох чулуулаг	
		m <sup>3</sup>	m <sup>3</sup>	%	m <sup>3</sup>	%	m <sup>3</sup>	m <sup>3</sup>
B'-1	1872423.3	1208787.2	1.5	10097.0	0.09	596.8	663636.2	1725454.1
B'-2	354038.8	230970.9	1.5	1870.6	0.08	229.9	123067.9	319976.6
B'-3	174433.8	113791.9	1.5	921.6	0.07	123.5	60641.9	157668.9
Нийт	2400896.0	1553550.0	1.5	12889.3	0.08	950.2	847346.0	2203099.6

Уул уурхайн сайдын 2015 оны 09-р сарын 11-ний өдрийн 203 тоот тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын дагуу магадласан үйлдвэрлэлийн нөөцдөд шилжүүлэн тооцсон.

#### 1.4. Уурхайн хүчин чадал, дэд бүтэц

“Бишрэлт түшлэг” ХХК-ийн бутлан ангилах төхөөрөмжийн хүчин чадал нь цагт 40-45 м<sup>3</sup> барилгын чулуу бутлан ангилах хүчин чадалтай бөгөөд цагт хамгийн багадаа 40 м<sup>3</sup>-ийн хүчин

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

чадлаар ашиглах боломжтой байна. Бутлан ангилсан барилгын чулууны хэрэгцээний хувьд орд нь Сайншанд sumaас 17 км зйттай, хатуу хучилттай авто замаар холбогдсон нь гол давуу тал болж байгаа бөгөөд Сайншанд суманд хэрэгжих томоохон төслүүдэд барилгын чулууны үндсэн нийлүүлэгч болох бүрэн боломжтой байгаа тул 2022 ашиглалтын хүчин чадлыг ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу жилд 60.0 мян.м3 барилгын чулуу олборлон борлуулахаар төлөвлөлөө.

### Уулын ажлын горим

Уурхайн ажиллах горимыг тодорхойлоход районы уур амьсгал, цаг уурын байдал, барилгын чулууны борлуулалт, бүтээн байгуулалтын үетэй уялдуулан тооцоолов.

#### Хүснэгт 8. Уурхайн ажлын үргэлжлэх хугацаа

№	Ажиллах горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоогоор
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365
2	Улирлын чанартай сүл зогсолт /11.01-04.30/	хоног	181
3	Улс нийтээр амрах, баяр ёслолын өдрүүд /05.01-10.30/	хоног	7
4	Цаг агаарын хүндрэлээс шалтгаалсан сүл зогсолт	хоног	10
5	Засвар үйлчилгээнд зарцуулах сүл зогсолт	хоног	15
6	Жилийн бодит ажиллах хоног	хоног	152
7	Уулын ажил явагдах хоног	хоног	152
	Хоногт ажиллах ээлж	ээлж	1
	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
8	Бутлах цех ажиллах хоног	хоног	152
	Хоногт ажиллах ээлж	ээлж	1
	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12

Тус ордыг ашиглах бэлтгэл ажил болгон ажилчдын тосгоныг барьж байгуулах, тоног төхөөрөмжүүдийг тээвэрлэх, суурилуулах зэрэг ажлуудыг хийх бөгөөд тус ордыг ашиглах ашиглалтын сүүлийн жилд уурхайг хаах нөхөн сэргээх, суурин болон зөөврийн техник тоног төхөөрөмжүүдийг хураах барилга байгууламжуудыг буулгах зэрэг ажлууд шат дараалалтайгаар хийгдэнэ. уурхайн бэлтгэл болон хаалтын ажлыг оролцуулан тус ордыг нийт 15 жилийн хугацаанд олборлохоор төсөлд тусгаж байна.

### Ил уурхайн ашиглалтын системийн параметрүүд

Ордын уул-геологийн тогтоц, уул-техникийн болон ил уурхайн хүчин чадлыг харгалзан тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглалтын үйл ажиллагааг явуулна.

Хөрсийг гадаад овоолго, ашигт малтмалыг бутлан ангилах хэсэг хүртэл тус тус автосамосвалаар тээвэрлэх бөгөөд хөрс хуулалт, олборлолтын ажлыг өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэх болно.

#### Хүснэгт 9. Ашиглалтын системийн үндсэн элементүүд

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Тоо, хэмжээ
1	Доголын өндөр Хаалтын догол Ажлын догол	м	10-15 5
2	Доголын хажуугийн өнцөг	градус	

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	Ажлын догол Ажлын бус Ил уурхайн ерөнхий налуу		<55-60 <50 <50
3	Уурхайн траншей, замын өргөн	м	12
4	Мөргөцгийн ахилт (ээлжийн)	м	40
5	Экскаваторын орлын өргөн	м	12-25
6	Фронтын урт	м	50
7	<b>Ажлын талбайн хамгийн бага өргөн</b>	м	<b>20</b>

**Ил уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмж**

**Хүснэгт 10. Орд эзэмшигчид бэлэн байгаа тоног төхөөрөмжүүд**

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Тоо	Хүчин чадал
1	Экскаватор	Hyundai 300 LC9	1	1.3 м3
2	Ковш	Doosan 50	2	3 м3
3	Автосамосвал	Nord Benz	4	20 тн
4	Өрмийн машин	FlexiROC D30	1	90-150 мм
5	Өрмийн компрессор		1	
6	Дизель станц 100		1	

**Хүснэгт 11. Өрмийн машины үзүүлэлт**

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Хэмжээ	
1	Марк		FlexiROC D30	
2	Хошууны диаметр	мм	90-150	
4	Хамгийн их өрөмдөх гүн	м	25	
7	Суурилсан чадал	кВт	287	
8	Хөдөлгүүрийн төрөл		CAT C13, Tier III	
9	Явах хурд	км/цаг	3.5	
10	Үндсэн хөтлүүрийн төрөл		Дизель	
11	Mass	тн	13.6	



2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Зураг 3. Hyundai-300LC маркийн экскаватор



Хүснэгт 12. Экскаваторын үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон үзүүлэлт
1	Утгуурын багтаамж	м3	1.3
2	Сумны урт	М	5.5
3	Гарны урт	М	12.6
4	Утгалтын түвшин дэх утгах радиус	М	10.7
5	Утгалтын хамгийн их радиус	М	12.4
6	Утгалтын их гүн	М	7.6
7	Утгалтын хамгийн их өндөр	М	11.12
8	Утгалтын их өндөр	М	11.12
9	Их биеийн өргөн	ММ	2980
10	Их биеийн өндөр	ММ	3390
11	Эргэх тавцан хүртэлх өндөр	ММ	1500
13	Явах ангийн урт	ММ	4470
14	Явах ангийн өргөн	ММ	3540
15	Гинжний өргөн	ММ	600
16	Хөдөлгүүрийн чадал	кВт	150
17	Мөчлөгийн хугацаа	сек	28

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Зураг 4. NordBenz фирмийн 24тн даацтай автосамосвал



Хүснэгт 13. Автосамосвалын үзүүлэлт

№	Үзүүлэлт	Тоон утга
1	Хөдөлгүүрийн загвар	WP12G380E310
2	Хөдөлгүүрийн чадал, кВт (м.х)	280 (381) 2100 эрг/мин
3	Цилиндрийн тоо байрлал	Цуваа 6 (4 тактын)
4	Хамгийн их мушгих момент, Н*м	1600 эрг/мин
5	Ажлын эзлэхүүн, л	7.7
6	Түлшний савны багтаамж, л	420
7	Хүчний дамжуулгын төрөл	7DS180
8	Дугуй	14.00-24-24PR
9	Өөрийн жин, кг	63000
10	Ачаалал хуваарилалт, кг Урд тэнхлэгт Хойд тэнхлэгт	13000 25000
11	Даац, кг	24000
12	Оврын хэмжээ, мм (урт, өргөн, өндөр)	9100x3200x3850
13	Тэвшний геометр багтаамж, м3	16.6
14	Дээд хурд, км/цаг	50
15	Түлш зарцуулалт, л/100км	36
16	Эргэх хамгийн бага радиус, м	10

### Туслах тоног төхөөрөмж

Олборлосон ашигт малтмалыг тээвэрлэн түр овоолгод байршуулах ба тэндээсээ утгуурт ачигчаар автосамосвалд ачин борлуулалтад гаргана. Шимт хөрс хуулж түрэн бөөгнүүлсний дараа ачилтад утгуурт ачигч хэрэглэгдэнэ эдгээр ажилд 3 м3-ийн утгуурын багтаамжтай Doosan SD 300 маркийн утгуурт ачигч хэрэглэнэ.

#### Хүснэгт 14. Doosan SD300 утгуурт ачигчийн үзүүлэлт

Үзүүлэлт	Тоон утга
Зүтгэх хүч, кН	172
Циклийн хугацаа, сек	12
Утгуурын багтаамж, м3	3.0
Даац, тн	6
Хөдөлгүүрийн чадал, кВт	250
Оврын хэмжээ, м	8.73x 3.08x3.4
Өөрийн жин, тн	21
Ажиллах налуу	29 градус



2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Тэсэлгээний ажлын тооцоо

**Хүснэгт 15. Тэсэлгээний ажлын тооцоо**

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Уулын цул
1	Жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ	мян.м3	60.00
2	Тэсрэх бодисын хувийн зарцуулалт	кг/м3	2.79
3	Ил уурхайн доголын өндөр	м	5
4	Доголын улны эсэргүүцлийн шугам	м	4
5	Цооногийн диаметр	м	0.2
6	Илүү өрөмдлөгийн гүн	м	1
7	Цооногийн гүн	м	6
8	Цооногийн цэнэгийн урт	м	4.0
9	Цооногийн түгжээний урт	м	2.0
10	Цооног хоорондын зайд	м	3.0
11	Цооног ойртолтын итгэлцүүр	-	1
12	Эгнээ хоорондын зайд	м	3.0
13	Нэг метр цооногийн багтаамж	кг/м	31.4
14	Нэг цооногт орох тэсрэх бодисын хэмжээ	кг	125.60
15	Тэсэлгээний цооногийн эгнээний тоо	-	3
16	Нэг метр цооногоос гарах уулын цул	м3/м	8.3
17	Тэсэлгээний блокийн эзлэхүүн	м3	6000
18	Тэсэлгээний нэг цооногт хамаарах уулын цулын хэмжээ	м3	45.0
19	Тэсэлгээний блок дахь цооногийн тоо	ш	133
20	Тэсэлгээний блокийн өргөн	м	9
21	Тэсэлгээний блокийн урт	м	133
22	Нэг удаагийн тэсэлгээнд шаардлагатай тэсрэх бодисын хэмжээ	кг	16747
23	Тэсэлгээгээр үүсэх нурлын өргөн	м	9.9
24	Нурлын өндөр	м	4.8

**Хүснэгт 16. 2024 онд зарцуулах ТБ-ын нийт хэмжээ**

№	Шаардлагатай тэсрэх материал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Тэсрэх бодис /анфо, эмульс/	тн	167.5
2	Нонель	ш	2667
3	Цочир дамжуулах шижим, ДША	м	26667
4	Өдөөгч	ш	2667
5	Цахилгаан тэслүүр, ЭД	ш	200
6	Хором удаашруулагч	ш	900

### Уурхайн дотоод тээвэр, овоолго

Уурхайгаас жилд 60.0 мян.м<sup>3</sup> барилгын чулуу олборлож, 0.94 мян.м<sup>3</sup> шимт хөрс хуулж тээвэрлэж овоолгуудад байршуулахаар байна. Уурхайн тээвэр гүйцэтгэх шаардлагатай ажлуудын төрөл, хэмжээ:

**Шимт хөрсний тээвэр:** Ил уурхай → шимт хөрсний овоолго. Энэ нь хөрс хуулалтын ажлын үндсэн хэсэгт багтах бөгөөд дунджаар 0.8 км зайд тээвэрлэнэ. Нийт замын 80% нь ачаатай чиглэлд.

**Хүдрийн тээвэр:** Ил уурхай → дайрга хүлээн авах талбай. Ил уурхайн олборлолтын мөргөцгөөс ачих техникээр ачиж дайрга хүлээн авах талбай хүртэл тээвэрлэнэ. Тээврийн дундаж зайд 0.9-1.0 км.

Овоолго байгуулах талбайн гадаргуу нь толгодорхог, ерөнхийдөө налуу нь 2-3° байгаа нь чулуулгийн нуралтын хязгаараас доогуур үзүүлэлт юм. Доголын налууг үндсэн чулуулгийн дотоод үрэлтийн өнцөгтэй ижил утгаар авснаар гулсалт болон нуралт үүсэх магадлал бага юм. Доголын өндөр 15 м, налуугийн өнцөг 34° байна.

### Бутлан ангилах технологи

Түшлэг уулын барилгын чулууны ил уурхайгаас жилд 60.0 мян.м<sup>3</sup> чулуу олборлон үйлдвэрийн хэсэгт бутлан, ангилж 0-5 мм, 5-10 мм, 10-20 мм, 20-40 мм-ийн дайрга үйлдвэрлэн хэрэглэгчид нийлүүлнэ.

### Бутлан ангилах цехийн ажиллах горим

Бутлан ангилах үйлдвэрийн ажлын горимыг захиалагчаас өгсөн техникийн даалгаврын дагуу уурхайн ажиллах горимтой ижил 5-р сарын 01-ээс 10-р сарын 31 хүртэл ажиллахаар тооцлоо. Долоо хоногт амралтын нэг өдөртэй, 12 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжээр ажиллуулахаар төлөвлөв.

- Жилийн дулааны улирлын нийт хоног (5-10 сар) – 184 хоног
- Үндэсний баяр, ёслол, тэмдэглэлт өдөр амрах хоног – 7
- Цаг агаарын хүндрэлээс шалтгаалсан сул зогсолт – 10
- Засвар үйлчилгээнд зарцуулах сул зогсолт – 15
- Жилд ажиллах цэвэр хоног – 152 хоног
- Хоногт ажиллах ээлжийн тоо – 1
- Ээлжийн үргэлжлэх цаг - 12 цаг
- Бүтээгдэхүүний баланс


40 м<sup>3</sup>/цаг хүчин чадалтай дайрганы үйлдвэр. Энэ үйлдвэр нь цагт 107 тн /40 м<sup>3</sup>/ дайрга боловсруулж 0-5 мм, 5-10 мм, 10-20 мм, 20-40 мм-ийн дайрга үйлдвэрлэн хэрэглэгчид нийлүүлнэ.

**Хүснэгт 17. Бүтээгдэхүүний баланс**

Боловсруулах дайрга	Бүтээгдэхүүн, м3			
	0-5 мм /15 %/	5-10 мм /10 %/	10-20 мм /60 %/	20-40 мм /15 %/
Жилд 60000 м3	9000	6000	36000	9000
Хоногт 394.7 м3	59.205	39.47	236.82	59.205
Цагт 40 м3	6	4	24	6

**Зураг 5. Бутлах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн технологийн схем**

Анхны хүдэр /300/



2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

### Бутлан ангилах хэсгийн тоног төхөөрөмж

**Зураг 6. Чичиргээт тэжээгч**

№	Үндсэн үзүүлэлтүүд	QH-1854	
1	Хүлээн авах амсрын хэмжээ, мм	1800*5400	
2	Хүлээн авах хэсгийн хамгийн том ширхэглэл, мм	300	
3	Асгах завсрын өргөн, мм	350-450	
4	Хүчин чадал, м3/цаг тн/цаг	40 110	
5	Хөдөлгүүрийн хүчин чадал, кВт	18	

**Зураг 7. Хацарт бутлуур**

№	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	FS-4840	
1	Хүлээн авах амсрын хэмжээ,	мм	1200*1000	
2	Хүлээн авах хэсгийн хамгийн том ширхэглэл,	мм	300	
3	Асгах завсрын өргөн,	мм	95-165	
4	Үйлдвэрлэлийн хүчин чадал,	м3/цаг тн/цаг	40 110	
5	Хөдөлгүүрийн хүчин чадал,	кВт	90	
7	Хэмжээ, мм /W*L*H/	мм	3008*3663*3564	
8	Жин	тн	21	

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Зураг 8. Алхан бутлуурын техникийн үзүүлэлт**

№	Үндсэн үзүүлэлтүүд	CC-1680	
1	Хүлээн авах амсрын хэмжээ, мм	235-265	
2	Асгах завсрын өргөн, мм	20-60	
3	Бүтээмж, м3/цаг тн/цаг	40 110	
4	Хөдөлгүүрийн хүчин чадал, кВт	105	
5	Жин, тн	29	
6	Овор хэмжээс, мм	3705*1730*2452	

**Зураг 9. Туузан конвейеруудын техникийн үзүүлэлт**

№	Үндсэн үзүүлэлтүүд	B750, B800, B900, B1050	
1	Туузны өргөн, мм	1200	
2	Конвейерийн урт, м	<15	
3	Хөдөлгүүрийн хүчин чадал, кВт	1.5-3	
4	Шугаман хурд, м/сек	0.8-2	
5	Туузан зөөгүүрийн хүчин чадал, м3/цаг тн/цаг	40 110	

**Зураг 10. Доргилтот шигшүүр**

№	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	OP-2160	
1	Шигших торны хэмжээ	мм	1000*1500	
2	Шигших гадаргуугийн давхаргын тоо	ш	4	
4	Түүхий эд оруулах хамгийн том хэмжээ	мм	100	
5	Гүйцэтгэх хүчин чадал	м3/цаг	40	

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		т/цаг	110	
8	Хөдөлгүүрийн хүчин чадал, кВт	kW	19	

**Цахилгаан хангамж**

Цахилгааны эх үүсвэрийн хувьд УБТын Сайншанд ЭХУ-ийн 2-р ангийн Цахилгааны төвлөрсөн системээс 1.5 км зйтай байгаа тул цахилгааны хэрэглээг уг эх үүсвэрээс 10 кВ-ын 1.5 км агаарын шугам татаж 400 кВа дэд станцаар дамжуулан тэжээх нь тохиромжтой байна.

**Хүснэгт 18. Доргилтот шигшүүр**

№	Хэрэглэгчид	Toо	Суурилагдсан чадал, кВт	Нийт чадал, кВт
<b>Ил уурхай</b>				
1	Гэрэлтүүлэг	5	1.5	7.5
2	Дүн 1			7.5
<b>Бутлах үйлдвэр</b>				
1	Доргилтот тэжээгч	1	18	18
2	Хацарт бутлуур	1	90	90
3	Алхан бутлуур	1	105	105
4	Туузан конвейер	6	2.5	15
5	Шигшүүр	1	19	19
6	Дүн 2			247
<b>Уурхайн тосгон засварын газар</b>				
1	Уурхайн тосгон	1	25	25
2	Засварын газар	1	45	45
3	Гэрэлтүүлэг	6	1.5	9
4	Дүн 3			79
5	Нийт			322

## БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1. Уур амьсгал өнөөгийн төлөв байдал

**Агаарын температур.** Сайншанд орчмын нутгаар жилийн дундаж агаарын температур  $3.7^{\circ}\text{C}$  дулаан байдаг. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын температур  $23.1^{\circ}\text{C}$  дулаан байдаг. Үнэмлэхүй хамгийн их агаарын температур  $41.6^{\circ}\text{C}$  хүрч халдаг. Тус нутгаар  $41.6^{\circ}\text{C}$ -ийн үнэмлэхүй хамгийн их температур 5%-ийн хангамжтай буюу 20 жилд нэг удаа тохиолддог. Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сарын агаарын дундаж температур тус аймагт -  $18.2^{\circ}\text{C}$  хүйтэн болж үнэмлэхүй хамгийн бага температур  $-41.4^{\circ}\text{C}$  хүрч хүйтэрдэг.

**Хоногийн дундаж агаарын температур тодорхой заагийг дайрч гарах хугацаа, дулаан үеийн үргэлжлэл, нийлбэр температур.** Сайншанд орчмын нутгаар  $5^{\circ}\text{C}$ -ыг хавар нутгийн өмнөд хэсгээр 4 дүгээр сарын 12-ны үед дайран дулаарч намар 10 дугаар сарын 14-ны үеэр хүйтэрч нийтдээ 185 хоног  $5^{\circ}\text{C}$ -аас дулаан үе үргэлжилдэг байна. Харин  $10^{\circ}\text{C}$ -ыг хавар 4 дүгээр сарын 28-ны үед дайран дулаарч намар 9 дүгээр сарын 27-ны үеэр хүйтэрч нийтдээ 150 гаруй хоног  $10^{\circ}\text{C}$ -аас дулаан үе үргэлжилдэг. Агаарын температур  $0^{\circ}\text{C}$  дулаан үеийн нийлбэр температур  $3158.9^{\circ}\text{C}$ ,  $5^{\circ}\text{C}$ -аас дулаан үеийн нийлбэр температур  $3084.4^{\circ}\text{C}$ ,  $10^{\circ}\text{C}$ -аас дулаан үеийн нийлбэр температур  $2869.8^{\circ}\text{C}$  тус тус байдаг.

Агаарын үнэмлэхүй хамгийн их температур  $30^{\circ}\text{C}$ -аас халуун өдрийн тооны өөрчлөлтийг авч үзэхэд сүүлийн 30 жилд шугаман тренд 0,89 жил/өдөр буюу 27 өдрөөр нэмэгдсэн байна.

### 2.2. Агаарын чанар өнөөгийн төлөв байдал

**Хүхэрлэг хий.** Сайншанд сумын агаарын чанарын мэдээгээр 2014-2020 оны хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж  $12\text{-}20 \text{ мкг}/\text{м}^3$ -ийн хооронд хэлбэлзэж байсан ба 2014 оноос бага зэрэг буурч 2020 онд огцом өссөн байгаа нь ажиглагдаж байна. Харин сарын дундаж агууламжийн явцыг хараад галлагаа эхэлсэн саруудад нэлээд өсч зуны саруудад буурч байна. 2020 оны байдлаар хүхэрлэг хийн сарын дундаж агууламж нь  $2\text{-}14 \text{ мкг}/\text{м}^3$ , нэг удаагийн хамгийн их агууламж  $4\text{-}90 \text{ мкг}/\text{м}^3$  байсан ба 3 дүгээр сард хамгийн их утга  $90 \text{ мкг}/\text{м}^3$  хүрсэн нь 2002 оны хамгийн их агууламжтай харьцуулахад  $77 \text{ мкг}/\text{м}^3$ -ээр их байсан байна.

**Азотын давхар исэл.** Азотын давхар ислийн сарын дундаж агууламж 2020 оны байдлаар  $23\text{-}38 \text{ мкг}/\text{м}^3$ -ийн хооронд хэлбэлзэж өрөнхийдөө бохирдол нэгэн жигд, гэхдээ зуны саруудад бага зэрэг багасдаг нь харагдаж байна.

Жилийн дундаж агууламжийн явцаас жилээс жилд өрөнхийдөө өсөх хандлагатай бөгөөд сүүлийн 10 жилийн мэдээгээр хамгийн дээд агууламж (ХДА)-аас давсан бохирдолгүй байв. 2014 онд жилийн дундаж агууламж  $34 \text{ мкг}/\text{м}^3$  байсан бол 2020 онд  $28 \text{ мкг}/\text{м}^3$  болж буурсан байна. 2020 оны ажиглалтын дүнгээр азотын давхар ислийн нэг удаагийн хамгийн их агууламж  $44\text{-}89 \text{ мкг}/\text{м}^3$  байсан ба галлагаа эхэлсэнтэй холбоотой нэмэгдэж, 1 дүгээр сард ХДА-ын утгатай ижил үзүүлэлт бохирдол ажиглагдсан байна.

## 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Сайншанд сумын төвийн агаарын чанарын төлөв байдлыг бусад суурин газруудтай харьцуулахад агаар дах азотын давхар ислийн агууламж бага зэрэг өндөр байна.

Сайншанд сумын 2014-2020 оны хоорондох PM10 тоосонцорын хэмжилтийн дүнг дээрх графикаас харвал 2015, 2016, 2017 онуудад MNS 4585:2016 стандарт буюу зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлттэй байсан байна. 2018 оноос хойш PM 10 тоосонцорын хэмжээ харьцангуй багассан байна.

### 2.3. Газрын гадарга, хэвллий өнөөгийн төлөөв байдал

Райноны талбай нь Монгол Улсын тектоникийн 1:1 000 000-ын масштабын зурагт тектоникийн мужлалаар Өмнөд Монголын супер-блокийн Умарт Говийн супертеррейний Гурван сайхан террейн болон Өмнөт Говийн супертеррейний Говийн Тэнгэр уул тэррэйний Цохиот сүбтеррейнд хамаарна. Энэхүү 2 террейн нь зүүн хойш чиглэлэтэй Говийн Тэнгэр уулын хагарлаар зааглагддаг. Гурван сайхан террейн (арлан нум). Энэхүү террейн нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд Зөвлөнгийн нуруу, Гурван сайханы нуруу Их Шанхайн нуруугаар дамнан зүүн тийш Буйр нуур хүртэл үргэлжилдэг. Тэрээр тохост-атираат тогтоцтой меланжсан меланократ суурьтай структур бөгөөд тохоснуудад нь прежидоли-доод девоны диабаз- занарын, дунд-дээд девоны бөсөллөг терриген, миссисипийн флишлэг-терриген (Ихшанх уул К-48-9-Г) голлох үүрэгтэйгээр оролцдог.

Гурван сайхан болон Зөвлөнгийн нуруунуудад хийгдсэн геологи-петрологийн судалгаагаар дээр дурьдагдсан диабаз- занарын бүрдлийн базальтоидууд нь арлан нумын хэв шинжийн толеитийн серид хамарагдахын зэрэгцээ ул суурийн официальцит-радиолярт хасын нимгэн багц үетэйгээр серпентинитийн меланжийг нийцлэг бусаар хучиж тогтсон.

Их Шанхын болон Хөх толгойн хагарал, мезозойн Цэцээ уулын хотгор, палеогений Хөх Овооны худагийн хотгор, неоген-дөрөвдөгчийн Урд боргилын хотос, Шинэ гүний худагийн хотос, Өвөр хонгилийн хотос зэрэг структурийн элементүүдийг ялгасан байна.

Геологийн формациын хувьд Гурван сайхан террейнд миссисип серийн Ихшанх (C1is), Гүнбаян (C1bg3) пеньсильваний Дөшийн-Овоо (C2do), сизуралийн серийн Аргалант (P1ar), доод цэrdийн Цагаанцав (K1cc), Манлай (K1mn), Хөхтээг (K1ht), Баруунбаян (K1bb), дээд цэrdийн Улаанговь (K2ug), Баянширээ (K2bs), Цогт-Овоо (K1cg) болон олигоцен (E2-3), плиоцен (N2), дөрөвдөгчийн хурдас чулуулгүүд, түрүү пермийн лейкократ гранитаас бүрдэнэ.

Тасралт эвдрэлүүд: Судалгааны талбайд давтамж далайцаараа ялгаатай, янз бүрийн чиглэл бүхий тасралт эвдрэлүүд олонтаа тохиолдоно. Эдгээрийн дотроос ихээхэн зайд үргэлжилэх, геологийн хөгжилд зонхилох нөлөө үзүүлсэн хагарлуудыг региональ гүний хагаралд хамааруулсан байна. Хагарлуудыг үссэн цаг үе, гүн идэвхжил зэрэгт үндэслэн ангилах нарийвчилсан судалгаа хийгдээгүй тул тэдгээрийн талаар хойно тоймлон бичиглэл хийжээ. Голлох хагарлуудыг зурагт үзүүлж, параметрийнх нь талаар дор өгүүлэв. Эдгээр хагарлууд нь раионы талбайг, ялангуяа Говийн Тэнгэр уулын структур формациын бүсийг блоклог тогтоцтой болгожээ. Үүнээс гадна тасралт эвдрэлүүд нь янз бүрийн цаг үед, өөр өөр гүнд үүсэж, дахин сэргэж, залуу хагарлуудаар тасран шилжиж зөрсөн байдаг. Мөн хагарлууд нь ихэвчлэн босоо, хааяа налуу уналтай, зонхилон зүүн хойш болон баруун хойш чиглэлтэй юм.

#### 2.4. Төслийн талбайн гадаргын усны төлөөв байдал

Сайншанд, Өргөн сум болон Түшлэг уул орчимд ил задгай ус үндсэндээ байхгүй. Харин нам толгорхог уул нуруудаас гэнэтийн аадар бороо эсвэл уруйн үер буух үед үерийн шинжтэй түр урсгалууд үүсдэг. Дорноговийн Сайншанд цаг уурын станцын мэдээнээс харахад Сайншандад 121 мм (1976 оны 7 дугаар сарын 11) тунадас унаж байсан ба 1 цаг хүрэхгүй шахам хугацаанд 40-65 мм хур буух тохиолдол энэ бүс нутгийн хаана ч тохиолдож болохыг харгалзан төсөл хэрэгжих нутаг уруу орж буй сайруудаар буух үерийн усны хэмжээг тооцоолов. Үерийн их өнгөрөлтийг тооцоолдог олон арга, эмперик томъёонууд байдгийн дотроос судалгааны ажлын хүрээнд ажиглалт хэмжилт дутагдалтай үед гол горхи, судаг сайраар өнгөрөх үерийн их урсацыг тооцоолдог хур борооны эрчимшлийн аргыг хэрэглэв. Гол горхи, хуурай сайруудын үерийн хамгийн их урсац 200 км<sup>2</sup>-ээс бага ус хураах талбайн “Ус зүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм” БНБД 2.01.14-86-д заасны дагуу хур борооны эрчимшлийн аргыг ашиглан тооцоолов.

$$Q_{1\%} = q_{1\%} \cdot \varphi H_{1\%} \cdot \delta \cdot p\% \cdot A$$

Энд:  $Q_{1\%}$  – үерийн их урсац, м<sup>3</sup>/сек

$q_{1\%}$  – үерийн их урсацын модуль, л/сек км<sup>2</sup>

$\varphi$  – үерийн урсацын коэффициент

$H_{1\%}$  – 1%-ийн хангамжтай хоногийн хамгийн их тунадас, мм

$\delta$  – нууршил, ой, намагшилтын коэффициент

$p\%$  – 1%-ийн хангамжаас шилжих коэффициент

$A$  – ус хураах талбай, км<sup>2</sup>

Урсацын хамгийн их модулийг ( $q_{1\%}$ -ийг) тодорхойлоход шаардагдах гольдрилын хэлбэр зүйн тодорхойлолт  $\Phi_r$ -ийг дараах томъёогоор тодорхойллоо.

$$\Phi_{x,6} = (1000 \cdot L_{x,6})^{1/2} / n_{x,6} \cdot J_{x,6}^{1/4} \cdot (\varphi \cdot H)^{1/2}$$

Энд:  $\Phi_{x,6}$  – хажуу бэлийн хэлбэр зүйн тодорхойлолт

$L_{x,6}$  – ус хураах талбайн хажуу бэлийн дундаж урт, км

$J_{x,6}$  – хажуу бэлийн дундаж хэвгий

$n_{x,6}$  – хажуу бэлийн барзгарын коэффициент

Үерийн урсацын коэффициентийг дараах томъёогоор тодорхойлов.

$$\varphi = [C_2 \varphi_0 / (A + 1)^{n_5}] (L_{y,x} / 50)^{n_5}$$

Энд:  $C_2$  – эмперик коэффициент, ойн бүсэд 1.2,.govь хээрийн бүсэд 1.3 гэж авна.

$\varphi_0$  –  $F = 10 \text{ km}^2$ ,  $J_c = 50\%$  байх үеийн урсацын коэффициент

$n_5$  – хөрсний хэв шинж, механик бүтцээс хамаарах параметр

## 2.5. Хөрсөн бүрхэвч өнөөгийн төлөөв байдал:

Монгол орны хөрс-газарзүйн мужлалтаар бүсийн хэв шинжит заримдаг цөлийн (говийн) Бор хөрс зонхилон тархдаг Сайншандын хөрсний тойргийн өмнөд хэсэгт хамрагддаг. Хөрсний энэ тойрог нь өргөргийн бүсшилээр хойд талдаа цайвар хүрэн хөрстэй хуурай хээрийн бүсийн өмнөд зах, хээржүү цөлийн цайвар бор хөрстэй говийн дэд бүсийн хойд захын хоорондох өргөн зурvas газрыг эзлэх бөгөөд Сайхандулаан сумын баруун хилээс зүүн тийшэх ихэнх нутаг, Сайншанд сумын нутаг, Өргөн сумын нутгийг бараг бүхэлд нь хамарч улсын хил хүртэл үргэлжилдэг.

Зураг 11. Хөрсний тархалтын зураг



Сайргархаг хөрс Зүүнбаян багийн эргэн тойрны Баян өндөр (883 м), Зүүн ухаа (804 м), Хүрэн цав толгой (1004 м), Цаг хар толгой (830 м) зэрэг ухаа гүвээрхэг өндөрлөгүүдэд мөн тогтвортодог. Харин Сайншанд Өргөн сумын хоорондох Хайрхан уул (1120 м), Шанагын өндөр уул (1102 м), Хөөтийн хяр, Зүүн Баян багийн нутаг дах Тоосгонт уул (1069 м), Хөөвөрийн улаан уул (1270 м), Хаалга уул (1061 м), Сайхандулаан сумын Өндөр Жавхлант уул (1153 м), Өвөлжөө уул (1062 м) зэрэг хэрчигдэл ихтэй нам уулс нь заримдаг цөлийн **чулуурхаг Бор, сайргархаг Бор** хөрстэй юм. Ийнхүү Сайншанд хавийн нам уул, ухаа гүвээ, цав толгодын хөрсөөр төлөөлүүлж авсан сайргархаг Бор хөрс нь Дорноговь аймгийн хэмжээнд энд тэнд багахан талбайд ( $2670 \text{ km}^2$ ) тархсан энэ хөрсний 49.4%-ийг эзэлж байгааг дээрх хүснэгтээс харж болно.

## 2.6. Ургамлан бүрхэвч өнөөгийн төлөөв байдал

Дорноговь аймгийн нутаг дэвсгэр дээр байгалийн үндсэн бүсүүдээс цөлөрхөг хээр, цөлийн хээр ба говь, цөлийн бүс байдаг бөгөөд өргөргийн дагууд хойноос урагш зүгт тархалтыг товчлон тодорхойлбол цөлийн хээрийн бүсэд Даланжаргалан сумаас Сайншанд сумын арын газар нутаг, хээржүү цөлийн бүсэд Сайншанд сумаас урагш Замын үүд хүртлэх өргөргийн дагуух газар нутаг хамардаг. Жинхэнэ цөлийн бүс Хатанбулаг, Хөвсгөл сумдын нутагт хамаарах бөгөөд Хөвсгөл сумын нутаг дээр Төвд Харганын тархалтын ганцхан цэг тэмдэглэгдсэн байдаг. Ургамалжилт-газарзүйн хуваарилалтаар Дорноговь аймгийн нутаг дэвсгэр нь Евразийн хээрийн их мужийн Дорнод Азийн мужийн Манж-Монгол Дагуурын их хушууны Дорнод говийн хушууны Алтанширээгийн тойрог, Сахар-Говийн их мужийн Төв Азийн мужийн Монголын их хушууны Умард төв Говийн хушууны Сайншандын тойрог, Зүүн Галбын говь-Хөвсгөлийн ба Замын үүд-Хатанбулагийн тойргуудтай. Төслийн талбай нь ургамалжилт-газарзүйн хуваарилалтаар Сахар-говийн их мужийн Төв Азийн мужийн Монголын их хошууны Дорнод говийн хошууны Сайншандын хээржүү цөлийн гэсэн бие даасан тойрот хамаарах бөгөөд тойргийг ялгах зүйлүүд нь Гурвалсан Боролзот, Загасгалт хэвшинжийн бүлгэмдлүүд өргөн тархсан байдгаараа онцлогтой юм. Эдгээр бүлгэмдлүүд нь ихэнхдээ цав толгод, нам уулсын хайрга чулуурхаг болон үлдвэр хад чулууны илэрцтэй оройн хэсэг ба энгэр хажуугаар тархана. Харин төслийн үндсэн талбай дотор эдгээр ургамал байдаггүй. Учир нь энэ хэсэгт ихэнхдээ эртний нуурын гаралтай гуравдагч галавын улаан шавран хурдас бүхий хужир мараат хотгор, түүний хаязахын хэсгээр тархах цөлийн гаралтай сөөг (Хармаг, Азар, Улаанбударгана, Шар бударгана), заримдаг сөөг (Баглуур, Бор бударгана) ургамал давамгайлдаг. Мөн төслийн талбайн онцлогийг тодорхойлох ургамлууд гэвэл Монгол улсын Улаан номонд ховор гэж орсон ургамал байхгүй ч Төв Азийн унаган ургамалд тооцогдох хөмөл, борбударгана гэх мэт байна. Харин эмийн зориулалтаар ашиглаж болох зэлэн зангуу, нангиад зээргэнэ, потанины хотир зэрэг ургамлын нөөц нэлээд байна.

## Ургамлан нөмрөг

Дорноговь аймгийн нутаг дэвсгэр дээр байгалийн үндсэн бүсүүдээс цөлөрхөг хээр, цөлийн хээр ба говь, цөлийн бүс байдаг бөгөөд өргөргийн дагууд хойноос урагш зүгт тархалтыг товчлон тодорхойлбол цөлийн хээрийн бүсэд Даланжаргалан сумаас Сайншанд сумын арын газар нутаг, хээржүү цөлийн бүсэд Сайншанд сумаас урагш Замын үүд хүртлэх өргөргийн дагуух газар нутаг хамардаг. Дорноговь аймаг нь ургамалжилт-газарзүйн хуваарилалтаар Сахар-говийн их мужийн Төв Азийн мужийн Монголын их хошууны Дорнод говийн хошууны Сайншандын хээржүү цөлийн гэсэн бие даасан тойрот хамаарах бөгөөд тойргийг ялгах зүйлүүд нь Гурвалсан Боролзот, Загасгалт хэвшинжийн бүлгэмдлүүд өргөн тархсан байдгаараа онцлогтой юм. Эдгээр бүлгэмдлүүд нь ихэнхдээ цав толгод, нам уулсын хайрга чулуурхаг болон үлдвэр хад чулууны илэрцтэй оройн хэсэг ба энгэр хажуугаар тархана. Сайншанд сумын хэмжээнд нийтдээ 13 овог, 28 төрөлд хамаарах 40 зүйл ургамалтай. Эдгээрийн дотор сөөг 6, сөөгөнцөр 1, заримдаг сөөг 5, олон наст өвслөг ургамал 20, нэг ба хоёр наст өвслөг ургамал 8 зүйл байна. Түүнчлэн эмийн ургамлаас Зэлэн зангуу (*Tribulus terrestris*), Потанины Хотир (*Zygophyllum potaninii*), Сиберийн шарилж (*Artemisia sieversiana*) зэрэг 3 зүйл ургамал ихэнхдээ на хотос газар ба сайраар тохиолдов.

## 2.7. Төслийн талбай орчмын амьтны аймаг

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Монгол орны био-газарзүйн мужлалаар (Цэгмид 1969, Грубов 1982) Дорнод Говийн тойрогт хамарагдана. Дорноговийн тойрог нь хойд болон зүүн хойд талаараа Төв Халх болон Дорнод Монголын тойротой хиллэх тул амьтны аймгийн үндсэн бүрдэлд нь говь цөлийн амьтдын зэрэгцээ хээрийн амьтад цөөнгүй илэрдэг.

Гадаргын усны нөөц багатай цөлөрхөг хээрийн бүсэд хоёр нутагтан амьтдын тархалт хязгаарлагдмал байдаг. Хоёр нутагтан амьтдаас монгол бах *Bufo raddei* байх боломжтой юм. Харин мөлхөгчдөөс цөөнгүй зүйлийн газарзүйн тархалт төслийн талбайтай давхцаж байна. Монгол орны мөлхөгчдийн тулгуур бүтээлээс (Мөнхбаяр нар, 2001) үзвэл цоохор хонин гүрвэл *Phrynocephalus versicolor*, монгол гүрвэл *Eremias argus*, мөгий гүрвэл *Eremias multiocellata*, говийн гүрвэл *Eremias przewalskii*, рашааны мөгий *Elaphe dione*, бамбай хоншоорт мөгий *Gloydius halys* зэрэг зүйлүүд төслийн үйл ажиллагаанд хамрагдах нутагт ажиглагдах боломжтой байна.

Монгол орны шувуудын олонх нь нүүдлийн шувууд байдаг. Тэр тусмаа говь цөлийн бүсэд тааралдах шувуудын дунд нүүдлийн шувууд гол байр суурийг эзэлнэ. Дорноговийн нутаг нь ус нам гархаг газар, модлог ургамал багатай, тэгш талархаг тул шувуудын амьдрах орчин ядмаг газарт хамарагдана. Тус аймгийн шувууны талаар хэвлэлийн мэдээ хомс, бага судлагдсан байна. Гомбобаатар нарын (2011) “Монгол орны шувууны улаан данс” бүтээлээс шүүж үзэхэд Сайншанд, Өргөн сумын нутаг дэвсгэрт Монгол орны суурин шувуудаас шоорон эвэрт болжмор, монгол болжмор, хээрийн боршууу, монгол божирог, хадны бор шувуу, хон хэрээ, жунгаа, хөхвөр тагтаа, говийн ногтруу, шилийн сар, тарважи бүргэд, цармын бүргэд, начин шонхор, идлэг шонхор зэрэг зүйлүүд байдгийг дурджээ. Дорноговь аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх нүүдлийн шувуудын талаар шинжлэх ухааны нэг сэдэвт мэдээ баримт хомс байдаг. Монгол орны төвийн бүс болон дорнод бүс нутагт зусаж үржиж буй нүүдлийн шувуудын дийлэнх нь энэ аймгийн нутгаар дайран нүүдэллэдэг нь дамжиггүй.

Батсайхан (2010), Цэнджав (2004), Кларк (2006) нарын бүтээл болон өөрсдийн судалгааны үр дүнгээс шүүж үзэхэд Сайншандын нутаг дэвсгэрт жижиг хөхтөнөөс говийн алагдаага, шивэр алагдаага, бүрдийн шишигүүхэй, элсний зусаг, шар чичүүл, монгол чичүүл, үлийн цагаан оготно, зараа, туулай, махчикаас хярс үнэг, шар үнэг, саарал чоно, тал хээрийн тuruутнаас цагаан зээр, хар сүүлт зээр, уулын тuruутнаас аргаль хонь зэрэг хөхтөний зүйлүүд тархжээ (Зураг 12.10). Дээрх зүйлийн бүрдлээс үзэхэд энэхүү бүс нутгийн хөхтөн амьтад нь хээр, говь цөлийн холимог бүрдэлтэй болох нь харагдав. Монгол орны ховор ан амьтдаас цөөнгүй зүйл Дорноговь аймгийн нутагт тархжээ.

## БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Дайрганы үйлдвэрийн боловсруулах болон олборлох үйл ажилгаанаас үүсэх үндсэн агаар бохирдуулагчид болох тоос, тоосонцрын ялгарлын орон зайн тархалтын хэмжээг эх үүсвэрийн тооцоолол, цаг уурын үзүүлэлтүүд болон газрын гадаргын өндөршлийн төлвийг ашиглан тооцов. Ордын хувьд жилийн турш олборлолтын үйл ажиллагаа явагддаг тул тархалтын загварын үр дүнг Монгол улсын гадаад орчны агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага болох MNS 4585:2016 стандартын жилийн дундаж хүлцэх хэмжээтэй харьцуулав. Төслийн зүгээс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн хүрээг агаари хамгийн ихээр ялгаруулж байгаа агаар бохирдуулагч бодисын агаарын чанарын стандартын хүлцэх хэмжээнээс давсан бохирдолтой хэсгээр зааглан тогтоов.

Үйлдвэрийн дотоод тээврийн зам. Үйлдвэрийн дайрга үйлдвэрлэх хэсэгт түүхий эд тээвэрлэлтийн замаас үүсэх нийт тоос үйлдвэрийн бүсэд 50-180 мкг/м<sup>3</sup> байна, PM10 тоосонцор 20-50 мкг/м<sup>3</sup> агууламжтай ялгарч байна.

Дайрганы үйлдвэр. Дайрга боловсруулах үйлдвэр орчим нийт тоосонцрын агууламж 500-7100 мкг/м<sup>3</sup>, PM10 тоосонцор 100-730 мкг/м<sup>3</sup> агууламжтай ялгарч байна.

#### Ордын нийт үйл ажиллагаанаас орчны агаары чанарт нөлөөлөх, нөлөөллийн хүрээ.

Ордын ашигт малтмал олборлох болон бүтээгдэхүүн боловсруулах үйл ажиллагаанаас үүсэх гол агаар бохирдуулагч нь нийт болон PM10 тоосонцор байна. Орд орчим агаарын чанарын стандарттаас 1-5 дахин давж орчны агууламжийг нэмэгдүүлж байна. Ордтой хамгийн ойр орших сууршилийн бүсэд нийт тоосонцор 8мкг/м<sup>3</sup> болон түүнээс багаар, PM10 тоосонцор 3 мкг/м<sup>3</sup> болон түүнээс багаар орчны агууламжийг нэмэгдүүлж байна.

### 3.2. Газрын гадарга, хэвлий болзошгүй нөлөөлөл:

#### Бодитой нөөцийн В-I блок

В-I блокын талбай цооног №-1,2,3,4,5,6,7,8,9 –ээр хязгаарлагдана. В-I нөөцийн блокын талбай 16828.41 м<sup>2</sup>, зузаан нь 40,0 м, ашигт малтмалын нөөцийн хэмжээ ашигт малтмалын нөөцийн хэмжээ 673136.4 м<sup>3</sup> буюу 1750154.6тн байна.

#### Боломжтой нөөцийн С-II блок

С-II блокын талбайг хайгуулын цооног №-1,5,7,9, болон геологийн цэг №-1,2-р хязгаарлан авч нөөцийг блокын аргаар бодлоо. Блокын талбайн хэмжээ 7283.94 м<sup>2</sup>, зузаан нь 40,0 м, ашигт малтмалын нөөцийнхэмжээ 291357.6 м<sup>3</sup> буюу 766270.5тн. байна.

#### Боломжтой нөөцийн С-III блок

С-III блокын талбайг хайгуулын цооног №-2,3,4, болон ажиглалтын цэг №-3,4-р хязгаарлан авлаа. Блокын нөөцийг блокын аргаар бодлоо. Блокын талбайн хэмжээ 4236.11 м<sup>2</sup>, зузаан нь 40,0 м, ашигт малтмалын нөөцийн хэмжээ 169444.4 м<sup>3</sup> буюу 445638.8 тн. байна.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

### 3.3. Усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Түшлэг уулын барилгын чулууны ордыг ашиглах төслийн 5 жилийн хугацаанд нийт 12.566 мян.м<sup>3</sup> ус шаардлагатай ба жилд 2513 м<sup>3</sup> буюу 45.52 м<sup>3</sup>/хон ус шаардлагатай байна. Төслийн унд ахуй, зам талбай, ногоон байгууламжийн усалгааг Сайншанд дахь гүний худгийн усаар зөөврөөр хангах бөгөөд худгийн ундрага нь 3 л/с буюу 259.2 м<sup>3</sup>/хон байгаа нь хангалттай хүрэлцэж байна. Ус ашиглах гэрээг хавсаргав. Мөн барилгын чулууны ордын хайгуулын үйл ажиллагаанд 43 м хүртэл өрөмдөхөд гүний ус илрээгүй нь тогтоогдсон байна.

#### Хүснэгт 19. Төслөөс усны чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн төрөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал
Бохирдолт	Жорлон, бохир ус, байгууламжийн ёроолоор доош шүүрэх Ахуйн болон техникийн бохир, угаадас усыг ил задгай асгах Ахуйн болон шатах тослох материалын хаягдал Шатах тослох материалыг тээвэрлэх, савлах явцад техникийн бүрэн бус байдал инженер-техникийн ажилтнуудын анхаарал хайхрамжгүйн улмаас асграх, гоожих	Нүх, сүвэрхэг дөрөвдөгчийн сийрэг (делювиально-пролювиальный) хурдсанд бохир ус хялбар шингэж улмаар хөрс гүний ус бохирдуулна. - Бохир болон техникийн шингэн ургамлын амьдрал, өсөлт хөгжилтэд сөргөөр нөлөөлж, зарим тохиолдолд устгаж үхүүлнэ. - Хур борооны усаар угаагдаж гадаргын болон хөрсний усыг бохирдуулах магадлалтай. -хөрс, хөрсний усыг бохирдуулна.

### 3.4. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Ордын ашиглалтын нийт хугацаанд ил уурхайн олборлолтод 9.61 га газар эвдэгдэж, ашиглалтын төгсгөлд нийт 22.35 га талбайд нөхөн сэргээлт хийх шаардлагатай болно.

#### Хүснэгт 20. Уурхайн эвдрэлд орох талбай

№	Эдэлбэр газруудын нэр	Талбайн хэмжээ	
		м <sup>2</sup>	га
1	Уурхай	55459.0	5.55
2	Хөрсний овоолго	9386.0	0.94
3	Уурхайн гадаргуун зам	5799.3	0.58
3	Уурхайн тосгон	5599.9	0.56
4	Үйлдвэрлэлийн талбай	19826.3	1.98
	Нийт	96070.4	9.61

Барилгын чулууны ордын ашиглалтын төгсгөлд 30 м гүн, 794 м урт, 150 м өргөн ухаш үүснэ.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Хүснэгт 21. Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл**

Нөлөөллийн төрөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал
Эвдрэл	Хүнд механизм, авто-машин үйлдвэрийн орчныг хэт талхлаж зам олшрох	23.25 га талбай нөлөөлөлд өртөнө. - Хөрсний физик-механик шинж чанар өөрчлөгднө. - Ямар нэг хэмжээгээр нөхөн сэргээх боломжтой
Бохирдол	Шатах, тослох материалын болон ахуйн хог хаягдал	Хөрс бохирдож, хөрсний микробиологийн шинж чанарт өөрчлөлт орно.

**3.5. Ургамлан бүрхэвчид, амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл**

**Хүснэгт 22. Төслөөс ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл**

Нөлөөллийн төрөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал
<b>Амьтан</b>		
Дуу чимээ	Бүх үйл ажиллагаа	- Дайжна. - Хөрсөн дэх бичил биетэн, шавьж хорхой устаж болно.
Хордолт	Шатах тослох материалын болон ахуйн хаягдал	Удамшил генд өөрчлөлт орох магадлалтай.
<b>Ургамал</b>		
Устах	Үйлдвэрийн ойролцоо зам жим олшрох, халцлагдах	төрөл зүйл өөрчлөгджэх (шарилж зэрэг хог ургамал олшрох) болно. Хэмжээ хязгаарлагдмал
Талхлагдах	Машин хөлхөж хүний үйл ажиллагаанд байнга өртөх	Зам талбай, обьектуудын орчны фито болон биомассын хэмжээ багасна төрөл зүйл устаж болно
Хордолт	Машин механизмын засвар үйлчилгээнээс гарах бохир хог, химийн хорт бодис (тос масло зэрэг) шингэнийг ил задгай хаях, урсгах	нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болно хэмжээ хязгаарлагдмал
Деградацид орох	Үйлдвэрийн орчныг хэт талхлах, олон салаа зам гарах, ялангуяа хүнд машин механизм ихээр холхих, хог новш ил задгай эмх цэгцгүй	ургамал нөмрөг эргэлт буцалтгүй устаж, удамшил генд өөрчлөлт орж болно төрөл зүйл хомсдон хэмжээ хязгаарлагдмал

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	хаях, орчныг хэт бохирдуулах Үйлдвэрийн орчны ургамал нэмрөг, хөрс сүйтгэгдэх устах	Үйлдвэрийн байгалийн унаган ургамал, хөрсөн бүрхэвч талхлагдаж, эвдэрч алга болох	орчинд
--	--	---	--------

**3.6. Нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөлөл:**

Барилгын чулууны ордод нийт 24 хүн шинээр ажлын байраар хангагдах бөгөөд дүүргийн хөдөлмөрийн хэлтэстэй хамтран ажилгүй иргэдийг ажлын байраар хангахаар төлөвлөсөн байна.

**Хүснэгт 23. Төслийн нийгэм эдийн засгийн нөлөөлөл**

Нөлөөллийн төрөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал
<b>Дайрга үйлдвэрлэх</b>	Эдийн засгийн чадавх дээшилнэ.	-Эерэг нөлөө их -Улсын болон орон нутгийн төсөвт орлого орно -Тогтмол бус
<b>Ажлын байр бий болно.</b>	Шинээр ажиллагсад ажилд авна	Байнгын найдвартай ажлын байр

## БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Бишрэлт түшлэг” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Түшлэг уул барилгын чулууны ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

Бишрэлт түшлэг ХХК-ийн Түшлэг уул Барилгын чулууны ордыг ашиглах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгалаа.

Бишрэлт түшлэг ХХК-ийн Барилгын чулууны ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож орууллаа.

Бишрэлт түшлэг ХХК-ийн нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө (5 жил)-нд үндэслэн боловсруулав.

## БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд техник хэрэгслээс агаарт тархах хорт утааг бууруулах, тоосжилтийг бууруулах зорилгоор замын усалгааг хийх, мониторингийн цэгүүдэд хяналт хийж дээжлэлт хэмжилт хийх ажлуудыг тусгаж өгсөн. Түшлэг уул Барилгын чулууны ордыг ашиглах төсөл нь нийт 15 жил ажиллах бөгөөд эхний 5 жил техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг ТЭЗҮ, БОННҮ-ий тайланд төлөвлөгдөгүй байна. Иймд үржил шимт хөрсийг салхиний нөлөөгөөр хийсэхээс хамгаалан үр цацаж хамгаалахаар төлөвлөсөн. Энэхүү ажлын нийт зардалд **1 622 000** төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Хүснэгт 24. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Замын хөдөлгөөны аюулгүй байдал аваар осол гарч болзошгүй.	Замын-үүд чиглэлийн авто замаас талбайгаас уурхай хүртэл замд замын тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Төв замаас уурхай хүртэл	1 км	30,000 төг	10	300,000	6-8 сард байршуулна	MNS4585:2007 (Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага)
2	Агаарын чанарт, тоосжилтийг хэмжих	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Уурхайн талбай		ОХШардалд тусгаса	тээвэрлэлтийн зам, уурхайн кемп	---	7-р сард жилд 1 удаа	MNS3383:1982 (Агаар мандал, Бодирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт)  MNS5885:2008 (Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац, Техникийн ерөнхий шаардлага)
3	Уурхайн ажилчдын байр орчимд бохирдол үүсэх	Уурхайн хогийн цэг, бие засах газруудад ариутгал халдвартгуйжүүлэлт хийх	Хогийн цэг, бие засах газар	Ш	12000	6	72000	Сард 1 удаа	

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
4	Зэрлэг ан амьтан усны хомсдолд орох	Зэрлэг ан амьтанд зориулан ундаалах цэг байгуулна	Түшлэг уул орчимд	ш		1	2000 000		
5	Хөрсний бохирдол үүсэх	Стандартын شاардлага хангасан нүхэн жорлонг бий болгох	Кемп	Ш	940 000	1	Үйл ажиллагааны зардалд оруулах	1 удаа	MNS5924-2015 Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага
<b>Нийт</b>							<b>2372 000</b>		

## БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны хувьд уурхайн ашиглалтын карьерт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхгүй.

### Хүснэгт 25. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах зүйн бичиг	Эрх
1	Техникийн нөхөн сэргээлт	2024 онд уурайн үйл ажиллагаа шинээр эхэлж байгаа тул уурхайн ашиглалтын карьерт техникийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.	×	×	×	×	×	×	×
2	Биологийн нөхөн сэргээлт	2024 онд уурайн үйл ажиллагаа шинээр эхэлж байгаа тул уурхайн ашиглалтын карьерт биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.	×	×	×	×	×	×	×

## БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ


### 7.1. Эвдрэлд орж орхигдсон газрын нөхөн сэргээлт

Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайландаа дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газар нутгийн хэмжээ ба дүйцүүлэн хамгааллын зардлыг тооцож тусгасан байдаг. Өмнөх жил Хавцгайт газар хийсэн нөхөн сэргээлтийг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөсөн.

Монгол улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарийн хамтарсан 167, A/698, A/336, A242 тушаалын дагуу нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай Засгийн газрын 2020 -2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8000 га талбайг нөхөн сэргээх зорилтыг хангах, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас Хавцгай нэртэй талбайг санал болгосон.

Дорноговь аймгийн Өргөн сумын засаг даргын тамгын газраас Бишрэлт түшлэг ХХК-д 1.6 га талбайд 83493 м3 талбайд нөхөн сэргээлт хийхийг санал болгосон бөгөөд энэхүү талбайгаас 2024 онд 2500 м3 талбайд гүйцэтгэхээр төлөвлөсөн.

#### Зураг- 1. Талбайн байршил Еic.mp сайтын эвдэрсэн газрын мэдээллийн сангаас авсан координат



2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Хүснэгт- 1. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ**

Аймаг сумын нэр	Байршлын нэр	Талбайн нэр	Урт	Өргөн	Нийт талбай, га	Нийт хэмжээ м3
Дорноговь, Өргөн сум	Улаан гүү 1	Хавцгай 1	240.2	86.9	1.65	83493

**Гүйцэтгэх ажлын хэмжээ**

1	Эзлэхүүн	Гүн	Талбай
2	2500	1.5	

**Бульдозерын ажлын хэмжээ**

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	CAT D6
1	Ээлжийн үргэлжлэх хугацаа	T <sub>цаг</sub>	12
2	Өнхрөх призмийн эзлэхүүн	V <sub>өп</sub>	7.74
3	Цаг ашиглалтын коэф	K <sub>ца</sub>	0.85
4	Сийрэгжилтийн коэф	K <sub>c</sub>	1.2
5	Ажлын мөчлөгийн хугацаа	t <sub>бм</sub>	73.79
6	Хусуурын өндөр	h <sub>x</sub>	1.24
7	Хусуурын урт	I <sub>x</sub>	4.36
8	Өнхрөх призийн хажуугийн өнцөг	q <sub>өп</sub>	30
9	Хусаж цуглуулах зайд	I <sub>хц</sub>	3
10	Хусаж цуглуулах хурд	V <sub>хц</sub>	0.2
11	Түрэх зайд	I <sub>т</sub>	15
12	Түрэх хурд	V <sub>т</sub>	0.65
13	Хөдөлгөөний хурд	V <sub>x</sub>	0.7
14	Хурд солих хугацаа	t <sub> xc</sub>	10
15	Техникийн бүтээл цаг	Q <sub>цаг</sub>	404.63
16	Хоногийн бүтээл	Q <sub>обэ</sub>	3237
17	Ажиллах хоног	A <sub>x</sub>	8.70
18	Ажиллах хоног	A <sub>x</sub>	1,1
19	Дундаж тулш зарцуулалт	мого/цаг	17
20	Ажиллах мого/цаг		11,8
21	Оператор цалин	сая.төг	2

Хажуугийн налуу үүсгэх хэмжээ

Нэхөн сэргээсэн газрыг ашиглах чиглэл	Налуулах өнцөг, градусаар
Хөдөө аж ахуйн эдэлбэр газар, газар тариалангийн талбай, бэлчээр	0-18
Ойн бүс, хамгаалалтын зурvas	0-25

$$z_{maw} = V_{maw} (1 + \varphi) \cdot \frac{a_{maw}}{10} \alpha_{maw} * L \text{ мөг}$$

$V_{tэгш}$  - анхан шатны тэгшлэлтэд хамрагдах эзэлхүүн, м3;

$\varphi = 0.24 - 0.3$   
 $a_{maw}$  - хоёр дахь давтан тэгшлэлтийг харгалсан кеофицицент  
 тэгшлэх ажлын өөрийн өртөг,

**Ухашиг хажууг хэвгийжүүлэх, дэвсэгжүүлэх ажлын зардал**

$$z_{dx} = \frac{a_{dx}}{10^3} \cdot V_{dx} \text{ мян.төг}$$

Здх- хэвгийжүүлэх, дэвсэгжүүлэх ажлын нийт зардал,  
 мян.төг;

адх- хажуу налууг тэгшилж хэвгийжүүлэх, дэвсэгжүүлэх ажлын өөрийн өртөг  
 төг/м3;

Vdx- хажуу налууг хэвгийжүүлэх, дэвсэгжүүлэх, ажлын эзэлхүүн, м3.

**Талбайг тэгшлэх ажлын зардал /шилт хөрс/**

$$z_{mm} = S \cdot h \cdot \frac{a_m}{10^3} \text{ мян.төг}$$

Зmm - талбай тэгшлэх зардал, мян.төг;

S - тэгшлэх талбайн хэмжээ, м<sup>2</sup>;

h- тэгшлэх хөрсний зузаан, м;

a<sub>m</sub>- 1.0 м<sup>2</sup> талбайг тэгшлэх ажлын зардал төг/м<sup>2</sup>.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Хүснэгт- 2. Бульдозер /оператор/ зардал**

Хоол	Түлш	Цалин	НДШ	Нийт
16423,17	562854,98	156411,17	22679,62	758368,94

**Хүснэгт 26. Техникийн нөхөн сэргээлтийн нийт зардал**

Тэгшлэх зардал	Цалин+Түлш	Нийт
3,223,067.99	758,368.94	<b>3,980 000</b>

**7.2.Тэрбум мод хөтөлбөрийн зардал**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 58 дугаар зарлигийн дагуу “Тэр бум мод тарих” үндэсний хөдөлгөөн санаачилсантай холбоотойгоор Бишрэлт түшлэг ХХК-ийн Түшлэг уул барилгын чулууны ордын талбайд 200 мод тарихаар төлөвлөлөө. Уурхайн хотхоныг салхины хүчээр босох тоосжилтоос хамгаалах зориулалтаар ойн зурvas байгуулах нь зүйтэй бөгөөд ойн зурvasын зориулалттай хурдан ургадаг үндсэн модны төрлөөс Улиас (*Populus spp.*) ба Хайлаас (*Ulmus pumila L.*) тарина. Тэрбум хөтөлбөрийн хүрээнд Өргөн сумын төвд улиас мод тарималжуулахаар төлөвлөсөн.

**Хүснэгт 27. Ногоон байгууламж байгуулах төлөвлөлт**

Хийгдэх ажил	Хэрэгжүүлэгч	Хугацаа		Шалгуур
		2024		
Өргөн сумын төвд мод тарих	Бишрэлт түшлэг ХХК	200 ширхэг мод		Байгаль орчны байцаагчийн тоо
Ногоон зурваст шаардлагатай арчилгаа тордолгоо хийх	Бишрэлт түшлэг ХХК	Жилд 10 удаа услах бөгөөд 1 модонд 40 литр усыг зарцуулна.		Байгаль орчны байцаагчийн дүгнэлт

**Ногоон зурвас байгуулах арга хэмжээний зардал**

Тарималжуулахад шаардагдах үр суулгацын тариалах норм, нормативыг тооцоходоо MNS 5918:2008 ургамалжуулах стандартыг үндэслэсэн бөгөөд газрыг нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгэний дагуу тарималжуулах ажлын эдийн засгийн тооцоог гаргалаа. Дээрх зардлын үнэлгээнд зааснаар 1.0 га талбайд мод, бутны суулгац 500-1500 ширхэг байхаар тооцоолон тарьдаг байна. Энэ норм хэмжээгээр тооцвол, нийт тарималжуулах талбайд 1000 ширхэг модлог ургамлын тарьц шаардагдана. 1 ширхэг модлог ургамлын тарьцын дундаж үнийг энд 4500 төгрөгөөр, арчилгаа, тордолгооны нэг жилийн зардлыг 1 ширхэг суулгацанд 3300 төгрөг байхаар тооцов. Говийн нөхцөлд арчилгаа тордолгоо их шаардлана.

**Хүснэгт 28. Ногоон байгууламж, ойн зурвас байгуулах ажлын зардал**

Хийгдэх ажил	Хэрэгжүүлэгч	Зардал төг (жилээр)	Нийт
		2024	

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Өргөн сумын төвд	Бишрэлт түшлэг ХХК Мэргэжлийн байгууллага	200x 4500 төг= 900 000	900 000
Ногоон байгууламж, ойн зурваст шаардлагатай арчилгаа тордолгоо хийх	Бишрэлт түшлэг ХХК	200 ш x 3300= 350 000	660 000
Нийт			<b>1250 000</b>

Бишрэлт түшлэг ХХК-ийн 2024 онд биологийн нөхөн сэргээлт, ногоон байгууламжид 1250 000 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

### 7.3. Хөв цөөрөм байгуулах

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд уурхайн талбайгаас урагш байрлах хур бороотой жил ус тогтдог байгалийн рельефтэй талбайд шүүрлийн усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулахаар зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, аймгийн байгаль орчны газраар батлуулах ажлыг төлөвлөлөө. Энэхүү ажлын зардал 5,000.000 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 29. Хөв цөөрөм байгуулах төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Зэрлэг амьтдын ундны усны эх үүсвэрийг бий болгох	Хулан, аргал амьтдын ундаалах үүсвэр болгох	зээр, зэрэг эх бий	Хөв цөөрөм байгуулах	-	1822 000	1822 000	2024 оны 6-10 сарын хооронд
	Нийт					1822 000		

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

## БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

## БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Соёлын өвийг хамгаалах тухай” Монгол улсын хуулийн 2014 оны 5 сарын 15 ны өдрийн шинэчлэсэн найруулгын 5.1.1; 6.1.5; 16.7.1; 17.1.3,4; 27.2; 28-р зүйл, 38.2,3; 60.1.10-д заасны дагуу газрын хэвлэлийг эзэмших ашиглахад палеонтологийн хайгуул тандан судалгааны ажлыг хийлгэх шаардлагатай байдаг. Уг хуулийн зорилго нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Эртний хүн, эртний амьтан, бичил биетэн, ургамлын чулуужсан олдвор, ул мөр, тэдгээрийг агуулсан олдворт газар нь түүх соёлын дурсгалт зүйлд хамаарна. Мөн БСШУ-ны сайдын 2015 оны А141 тоот тушаалаар “Соёлын өвийн судалгаа хийх журам” батлагдсан байна. ШУТИС, ГУУС-ийн Стратиграфи-Палеонтологийн судалгааны төв судлаач багш нараар тус ордын талбайд 2016 оны 06 сарын 18 өдөр палеонтологийн хайгуул, тандан судалгаа явуулж, эртний амьтан ургамлын олдвор, олдворт газар, илэрч болох магадлал буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгсөн байна. Судалгааны үр дүнгээр “Бишрэлттүшлэг” ХХК-ны Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт орших 2015/01IX (84.5 га) тоот “Түшлэг уул” нэртэй түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбайд эртний амьтан, ургамлын чулуужсан үлдвэр байхгүй болно. Бишрэлт түшлэг ХХК-ийн түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын 2015/01IX тоот тусгай зөвшөөрөлтэй Түшлэг уул хайгуулын талбайд археологийн дурсгалаар баялаг байж магадгүй хэмээн үзсэн талбайн төв болон баруун хойт талын аараг толгодын энгэр, наран тийш хандсан зүүн энгэр, зүүн талын энгэрээс буусан жижиг жалгануудын хажуу хавирга, энгэрээр хооронд 20-25 метр зайтайгаар энгийн шугаман хайгуулын аргаар ашигт малтмалын үйл ажиллагаа явуулах гэж буй талбайд хайгуул судалгаа хийсэн бөгөөд гадна талдаа ил мэдэгдэх тэмдэгтэй түүх, археологийн дурсгалуудыг илрүүлэхийг зорисон байна.

Энэ ажлын үр дүнд Бишрэлт түшлэг ХХК-ийн эзэмшдэг ашигт малтмалын хайгуулын Түшлэг уул талбайгаас 3 түүх, археологийн дурсгалууд илэрч мэдэгдлээ. Тэдгээрийг товч тодорхойлбол, Он цаг тодорхойгүй булш оршуулга -3 олж илрүүлсэн байна. Энэхүү 3 булш оршуулганд хашаа хамгаалалт хийж тэмдэгжүүлэн, түүнийг хөндөхгүй байхаар ажиллах .

Төсөл хэрэгжүүлэх явцад түүх соёлын дурсгалт зүйл нэмж илэрсэн тохиолдолд “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 17.12-д зааснаар газрын хэвлэлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл газрын хэвлэлийг ашиглагч нь ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Барилгын ажлын үед соёлын үнэт зүйлс шинээр тааралдвал, үүнийг Монгол Улсын Соёлын Өвийг Хамгаалах тухай хуулийн дагуу зохих газарт нь даруй мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авхуулах зэрэг болно.

Уурхай нь түүх соёлын дурсгалт зүйлс илрэх магадлалтай тул тухайн жилд 500.0 мян.төг зарцуулахаар төсөвлөж өгөв.

**Хүснэгт- 3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

